



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Чингэлтэй дүүргийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХАК-2022/769/НА-СА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2022 он

Эвиденсе аудит ХХК захирал,

Ахлах аудитор: С.Бадамгарав

Утас: 99057121

Цахим хаяг: info@evidenceaudit.mn

Аудитор: Б.Пушкин

Утас: 95047121

Цахим хаяг: pushkin@evidenceaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	11
3.8 Аудитын гол асуудал	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	12
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт	13
4.1 Залруулсан алдаа	13
4.2 Албан шаардлага	13
4.3 Зөвлөмж.....	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	

Товчилсон үгийн жагсаалт

НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амгын гудамж, Сойлын төв өргөө, Г хөрлөг, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (978-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2022 02 25 № 416

танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ
ДҮҮРГИЙН ХӨДӨЛМӨР,
ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА А.СЭРЭЭТЭР
ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Чингэлтэй дүүргийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Нийслэлийн Чингэлтэй дүүргийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд олгосон санхүүгийн дэмжлэгийн хугацаа хэтэрсэн 459,244.8 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй, тайлант онд 11,812.5 мянган төгрөгийн зээл хугацаандаа төлөгдөөгүй зөрчил нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 5.1.5, 6 дугаар зүйлийн 6.4.8, санхүүгийн тайлангийн "эрх ба үүрэг", "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

002020367



Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)	1,849,110,533.48	2,235,655,656.40
33	АВЛАГА	1,849,110,533.48	2,235,655,656.40
33700	Хөтөлбөртэй холбоотой авлага	1,640,882,816.00	1,769,016,944.49
33703	Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих	775,803,316.00	917,260,344.49
33705	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	334,901,500.00	347,475,500.00
33717	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ	77,995,000.00	99,702,500.00
33718	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих	383,683,000.00	336,078,600.00
33720	Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлөөс дэмжсэн орон нутгийн онцлогтой төсөл	68,500,000.00	68,500,000.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	208,227,717.48	466,638,711.91
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)	1,849,110,533.48	2,235,655,656.40
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)	47,900,000.00	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	47,900,000.00	-
41300	Өглөг	47,900,000.00	-
41330	Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг	47,900,000.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)	1,801,210,533.48	2,235,655,656.40
51	Засгийн газрын хувь оролцоо	1,801,210,533.48	2,235,655,656.40
51200	Хуримтлагдсан үр дүн	1,801,210,533.48	2,235,655,656.40
51210	Өмнөх үеийн үр дүн	1,595,907,549.62	1,640,882,816.00
51220	Тайлант үеийн үр дүн	205,302,983.86	594,772,840.40
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)	1,849,110,533.48	2,235,655,656.40

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,291,887,233.16	1,812,457,533.77
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	573,587,233.16	946,024,383.77
1200	Өмчийн орлого	573,587,233.16	946,024,383.77
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	573,587,233.16	946,024,383.77
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	573,587,233.16	946,024,383.77
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	718,300,000.00	866,433,150.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	417,300,000.00	866,433,150.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	62,300,000.00	11,885,000.00



131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	355,000,000.00	854,548,150.00
1350	Засгийн газрын тусгай зориулалтын сангаас санхүүжих	301,000,000.00	0
13503	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	301,000,000.00	0
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	1,086,584,249.30	1,217,684,693.37
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,086,584,249.30	1,217,684,693.37
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	16,400,000.00	16,433,150.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,000,000.00	-
210404	Ном, хэвлэл	1,000,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,400,000.00	8,048,150.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,000,000.00	6,048,150.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	2,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,000,000.00	8,385,000.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	12,000,000.00	8,385,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,070,184,249.30	1,201,251,543.37
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	422,134,515.68	485,277,071.86
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	422,134,515.68	485,277,071.86
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	115,867,308.62	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	67,967,308.62	-
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	47,900,000.00	
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	184,982,425.00	353,987,946.51
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	184,982,425.00	353,987,946.51
2132	Бусад урсгал шилжүүлэг	347,200,000.00	361,986,525.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	347,200,000.00	361,986,525.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	205,302,983.86	594,772,840.40
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)	205,302,983.86	594,772,840.40

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
D01	2020 оны 12 сарын 31-ээрх үлдэгдэл	1,801,210,533.48	1,801,210,533.48
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-160,327,717.48	-160,327,717.48
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,640,882,816.00	1,640,882,816.00
D08	Тайлант үеийн үр дүн	594,772,840.40	594,772,840.40
D09	2021 оны 12 сарын 31-ээрх үлдэгдэл	2,235,655,656.40	2,235,655,656.40



2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,485,744,658.16	1,812,457,533.77
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	767,444,658.16	946,024,383.77
1200	Өмчийн орлого	767,444,658.16	946,024,383.77
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	767,444,658.16	946,024,383.77
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	193,857,425.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	573,587,233.16	946,024,383.77
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	718,300,000.00	866,433,150.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	417,300,000.00	866,433,150.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	62,300,000.00	11,885,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	355,000,000.00	854,548,150.00
1350	Засгийн газрын тусгай зориулалтын сангаас санхүүжих	301,000,000.00	-
13503	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	301,000,000.00	-
14	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО	-	172,865,871.51
145	Бусад орлого (олз)	-	172,865,871.51
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	1,485,744,658.16	1,985,323,405.28
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,485,744,658.16	1,985,323,405.28
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	16,400,000.00	16,433,150.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,000,000.00	-
210404	Ном, хэвлэл	1,000,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,400,000.00	8,048,150.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,000,000.00	6,048,150.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	2,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,000,000.00	8,385,000.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	12,000,000.00	8,385,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,469,344,658.16	1,968,890,255.28
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	621,487,233.16	946,024,383.77
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	573,587,233.16	946,024,383.77
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	47,900,000.00	-



2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	193,857,425.00	359,879,346.51
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	193,857,425.00	359,879,346.51
2132	Бусад урсгал шилжүүлэг	654,000,000.00	662,986,525.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	654,000,000.00	662,986,525.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)	-	(172,865,871.51)
9	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	-	172,865,871.51
145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх	-	172,865,871.51
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VII)	-	172,865,871.51

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	866,433,150.00	866,433,150.00	-	100.00%
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	11,885,000.00	11,885,000.00	-	100.00%
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	854,548,150.00	854,548,150.00	-	100.00%
2	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	866,433,150.00	866,433,150.00	-	100.00%
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	866,433,150.00	866,433,150.00	-	100.00%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	866,433,150.00	866,433,150.00	-	100.00%
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	16,433,150.00	16,433,150.00	-	100.00%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	850,000,000.00	850,000,000.00	-	100.00%
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	187,013,475.00	(187,013,475.0)	100.00%
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	662,986,525.00	662,986,525.00	-	100.00%
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	662,986,525.00	662,986,525.00	-	100.00%



2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүнгээр	Хувь
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,118,890,255.28	1,118,890,255.28	-	100.00%
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	946,024,383.77	946,024,383.77	-	100.00%
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	172,865,871.51	172,865,871.51	-	100.00%
2	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,118,890,255.28	1,118,890,255.28	-	100.00%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	222,865,871.51	1,118,890,255.28	(896,024,383.77)	502.05%
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	50,000,000.00	485,277,071.86	(435,277,071.86)	970.55%
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	172,865,871.51	166,974,471.51	5,891,400.00	96.59%
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг СЯ		466,638,711.91	(466,638,711.91)	



3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Чингэлтэй дүүргийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Эвиденсе аудит ХХК-ийн ахлах аудитор Б.Пушкин, аудиторын туслах Э.Билгүүн нар гүйцэтгэж, хяналтыг захирал, ахлах аудитор С.Бадамгарав, НТАГ-ын аудитын менежер Д.Отгонбаяр, хэлтсийн дарга, аудитын менежер З.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Чингэлтэй дүүргийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Эвиденсе аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 1/140 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Чингэлтэй дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүн амын хөдөлмөрлөх эрхийг хангах боломж, нөхцөлийг бүрдүүлж, ажиллах хүчний мэргэжлийн ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх замаар хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг тэнцвэржүүлэн зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж ядуурлын түвшнийг бууруулах.
- Үндэсний хөдөлмөр эрхлэлт, халамжийн үйлчилгээний бодлогын хэрэгжилтийг дэлхийн жишигт хүргэн хөгжүүлэх.
- Нэг цонхны бодлогоор Монгол улсын иргэдийн дотоод, гадаадын мэргэшсэн хүний нөөцийн зах зээлд гарах гарц нь болох.
- Төрийн үйлчилгээг ил тод, нээлттэй, тэгш шударга, чанартай хүргэх чадварыг байнга дээшлүүлсэн суралцагч байгууллагыг хөгжүүлэх, стратегийн төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын чадамжийг дээшлүүлэх.
- Байгууллагын гадаад, дотоод харилцааг хөгжүүлж салбарын бодлогыг хэрэгжүүлэх, хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэх талаар хамтран ажиллах, төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх.
- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний цахим мэдээллийн нэгдсэн сүлжээг боловсронгуй болгож, төрийн зохих байгууллагуудын сүлжээ, мэдээлэлтэй нэгдмэл байдлыг хангах.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар батлагдсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил



гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Чингэлтэй дүүргийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл их гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 0.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 1,086,584.2 мянган төгрөгөөс 0.5 хувиар буюу 5,432.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 60.0 хувиар буюу 3,259.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Чингэлтэй дүүргийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 396,545.1 мянган төгрөгөөр буюу 21.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	1,849,110.50	2,235,655.60	386,545.10
Нийт хөрөнгө	1,849,110.50	2,235,655.60	386,545.10
Өр төлбөр	47,900.00	-	-47,900.00
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,801,210.50	2,235,655.60	434,445.10
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,801,210.50	2,235,655.60	434,445.10

Авлага дансны үлдэгдэл 2,235,655.60 мянган төгрөг болж 386,545.1 мянган төгрөгөөр өссөн нь санхүүгийн дэмжлэгийн авлага нэмэгдсэн нь шалтгаалжээ. Нийт авлагаас эрсдэлтэй 555,465.9 мянган төгрөгийн авлага байна.



Өр төлбөр дансны үлдэгдэлгүй болж 47,900.0 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн үйл ажиллагааны хөтөлбөртэй холбоотой өглөг, татаас санхүүжилтийн өглөгийг барагдуулсан нь шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,235,655.6 мянган төгрөг болж 434,445.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант оны үйл ажиллагааны үр дүнгээс шалтгаалжээ.

Чингэлтэй дүүргийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 520,570.3 мянган төгрөгөөр буюу 40.3 хувиар өссөн, нийт зардал өмнөх оноос 17,900.0 мянган төгрөгөөр буюу 17.2 хувиар өссөн байна. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөр 252 иргэний 946,024.3 мянган төгрөг, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт 828 иргэний 172,865.8 мянган төгрөгийг төвлөрүүлсэн.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг болон нийт зарлагыг 1,119,600.0 мянган төгрөгөөр тоохон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 5 хөтөлбөрийн 17 арга хэмжээг санхүүжүүлэхээр 866,433.1 мянган төгрөгийн төсөв баталснаас 866,433.1 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 854,548.1 мянган төгрөг, Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс 11,885.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бараа, ажил үйлчилгээний зардалд 16,443.1 мянган төгрөг, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулалд 662,986.5 мянга, нийт 679,419.6 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 187,013.4 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 946,024.3 мянган төгрөг, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтөөр 172,865.8 мянган төгрөг, нийт 1,118,890.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс 652,251.5 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж, татаас санхүүжилтийн авлагаар 466,638.7 мянган төгрөг шилжүүлсэн.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Асуудлыг онцолсон хэсэг:



Тайлант хугацаанд зорилтот бүлгийн иргэдэд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, ажилгүйдлийн тэтгэмжийн тодорхойлолт болон ажил идэвхтэй хайж хандсан иргэдийг бүртгэн авч ажил олгогч байгууллагаас ирсэн ажлын байрны захиалгын дагуу иргэдийг хүсэл сонирхол, дадлага туршлага, ур чадварыг нь харгалзан ажил олгогчийн шаардлагад нийцүүлэн тохирч тэнцэх ажлын байранд холбон зуучлах үйл ажиллагаа явуулсан.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Бусад асуудлын хэсэг:

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 17 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 100.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. Ингэхэд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

3.8 Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 17 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Чингэлтэй дүүргийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь 2021 онд нийт 2,338,566.5 мянган төгрөгийн 55 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 2,338,566.5 мянган төгрөгийн 55 мэдээллийг ил тод мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох зарим заалттай нийцсэн байна

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

3.10.1. Завсрын аудитын үр дүн:



2021 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар алдаа зөрчил илрээгүй.

3.10.2. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй.

3.11 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ

Хөтөлбөртэй холбоотой авлагыг гэрээ болон эргэн төлөлтийн хуваарийн дагуу хугацаандаа төлүүлсэн эсэх асуудлыг авч үзэх

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 476,339.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 471,057.3 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 5,282.1 төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой алдаа санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй.

4.2 Албан шаардлага

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 2015-2019 онуудад 315 иргэнд олгогдсон санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн 459,244.8 мянган төгрөгийн (үүнээс 2015 онд 11,229.0 мянган төгрөг, 2017 онд 120,403.3 мянган төгрөгийг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн), тайлант онд мөн хөтөлбөртэй холбоотой 87 иргэнд 301,000.0 мянган төгрөгийн эргэн төлөгдөх нөхцөлтэй зээл олгосноос тайлант хугацаанд эргэн төлөлтийн хуваарийн дагуу 32,507.0 мянган төгрөгийн авлагаас 45 иргэнтэй холбоотой 11,812.5 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй байгаа зөрчил нь Санхүүгийн дэмжлэг олгох гэрээ, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 5.1.5 “хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.8 “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6 “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, УСНББОУС-ын үндсэн шаардлага, санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Анхан шатны баримт бүрдүүлэхтэй холбоотой асуудал**

1.1 **Илрүүлэлт:** Тайлант хугацаанд цахим төлбөрийн И баримтын дүнгээс зөрүүтэй 5,282.1 мянган төгрөгийн төлбөр шилжүүлсэн /баримтын бүрдлийг ханган ажиллаагүй/. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7. "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно". Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар



Чингэлтэй дүүргийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

зүйлийн 17.3.2."бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно"; 17.6."Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй.

1.2 Өгсөн зөвлөмж: Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, цахим төлбөрийн баримтыг үндэслэн гүйлгээг шилжүүлэх, бүртгэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллага болон аудитын хуулийн этгээдэд 2022 оны 05 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн		/мянган төгрөгөөр/			
				Үүнээс		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал:							
1	Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн 459,244.8 мянган төгрөгийн, 2021 онд мөн хөтөлбөртэй холбоотой 87 иргэнд 301,000.0 мянган төгрөгийн зээл олгосноос тайлант хугацаанд эргэн төлөлтийн хуваарийн дагуу 32,507.0 мянган төгрөгийн авлагаас 45 иргэнтэй холбоотой 11,812.5 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй	1	471,057.3	1	471,057.3		
2	Тайлант онд ААН, хувь хүнээс 5,282.1 мянган төгрөгийн худалдан авалтын НӨАТ-ын төлбөрийн цахим баримт гаргуулан аваагүй байна.	1	5,282.1			1	5,282.1
Дүн			476,339.4	1	471,057.3	5	5,282.1

Аудитын тайланг хянасан:

Эвиденсе аудит ХХК-ийн захирал



Б.Бадамгарав Б.Бадамгарав

Бэлтгэсэн:

Ахлах аудитор

Аудиторын туслах

Б.Пушкин Б.Пушкин
Э.Билгүүн Э.Билгүүн